

Оролцогчдын оноо тэнцсэн тохиолдлыг шийдвэрлэх

1. Удирдамжийн 3.2-д зааснаар олимпиадыг CMS системийг ашиглан явуулахдаа оролцогч бүрд өгсөн 3 бодлогын хувьд нийт 90 удаа бодолт илгээн үнэлгээ хийлгэх эрх олгох бөгөөд хоёр дараалсан илгээлтийн хоорондох хугацаа 30 секунд байна.

2. Олимпиадад оролцогчдын оноо шагналт байрт тэнцсэн тохиолдолд дараах дүрмээр эрэмбэлнэ. Үүнд:

2.1. Бүтэн бодолтын тоо олонтойг эхэнд нь эрэмбэлнэ. Жишээ:

Оролцогч	Бодлого1	Бодлого2	Бодлого3	Нийт оноо	Эрэмбэ
Оролцогч1	100	70	30	200	2
Оролцогч2	100	100	0	200	1

2.2. Дээрх шалгуураар эрэмбэлэгдэхгүй бол тэрхүү эрэмбэлэх боломжгүй бодлогуудын хувьд хамгийн өндөр оноотой шийдэл гаргасан оролцогчийг эхэнд эрэмбэлнэ.

2.3. Тохиолдлын жишээ 1

Оролцогч	Бодлого1	Бодлого2	Бодлого3	Нийт оноо	Эрэмбэ
Оролцогч1	100	70	30	200	2
Оролцогч2	100	20	80	200	1

Энэ тохиолдолд Оролцогч2 бүтэн бодоогүй үлдсэн хоёр бодлогын хувьд хамгийн өндөр буюу 80 оноо авснаар эхэнд нь эрэмбэлэгдэж байна.

2.4. Тохиолдлын жишээ 2

Оролцогч	Бодлого1	Бодлого2	Бодлого3	Нийт оноо	Эрэмбэ
Оролцогч1	60	90	50	200	1
Оролцогч2	70	70	60	200	2

Энэ тохиолдолд Оролцогч1 гурван бодлогын хувьд хамгийн өндөр буюу 90 оноо авснаар эхэнд нь эрэмбэлнэ.

2.5. Дээрх шалгуураар эрэмбэлэгдэхгүй бол оноо тэнцсэн бодлого тус бүрийн хамгийн эхэнд илгээсэн хугацааны дундаж хамгийн бага нь эхэндээ эрэмбэлэгдэнэ.

2.6. Дээрх 3-аар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх асуудлыг программчлалын олимпиадыг зохион байгуулах комиссоор хэлэлцэн шийдвэрлэнэ.

